



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/289

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, 2022 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолоор баталсан Ариун цэврийн байгууламжийн тогтмол зардлаас 132,985,200 (Нэг зуун гучин хоёр сая есөн зуун наян таван мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн “Хөвсгөл Ус Суваг” ХХК-д олгосугай.

2. Дээрх зардлын 132,985,200 (Нэг зуун гучин хоёр сая есөн зуун наян таван мянга хоёр зуу) төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу Засаг дарга дансны “Ариун цэврийн байгууламжийн тогтмол зардал”-аас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Тус зардлыг зориулалтын дагуу зарцуулан тайлагнаж ажиллахыг “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Лхагважав)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН